



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас/Факс: (976-11) 32-71-99,
<http://www.ulaanbaatar.mn>

2018.04.18 № 04-01/1459

танай _____ -ны № _____ -т


**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД,
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ**

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан иргэдийн өргөдөл, гомдлын 2018 оны нэгдүгээр улирлын шийдвэрлэлтийн байдлыг хэлэлцсэн тухай нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хавсралтаар хүргүүлэв.

Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрийн дотор ирүүлж ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН
ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.УУГАНБАТ



D:\2018\Toot\A-5ТГ.docx

111020001253



НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

"5. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын 2018 оны 1 дүгээр улирлын шийдвэрлэлтийн байдал, цаашид анхаарах асуудлын тухай танилцуулгыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбаяр танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулах, тэдний саналыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх талаар санаачилга гарган ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын дарга, удирдлагуудад;
2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд тогтмол дүн шинжилгээ хийж, нэгдсэн хяналтыг сайжруулан, өргөдөл, гомдол хүлээн авах цахим эх үүсвэрийн хэрэглээг нэмэгдүүлэх, иргэдэд сурталчлан таниулж ажиллахыг нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн орлогч дарга /Б.Ууганбат/-д;
3. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, нийслэлийн хороодоор иргэний өргөдөл, гомдлыг бүртгэх, уламжлах, шийдвэрлүүлэх ажлыг эрчимжүүлэхийг дүүргийн Засаг дарга нарт;

Танилцуулгад зөвлөлийн гишүүдийн саналыг тусган Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын 2018 оны 1 дүгээр улирлын шийдвэрлэлтийн тайланг 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

111020000213

111020000213